МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Юу Би Эйч төв, 8 давхар, Энхтайваны өргөн чөлөө 23,
1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 01 82

2024.01.03 № 01/11

танай ____________-ны №____________-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023 оны Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 24 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЭНХТУЯА

1424 160027

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

/2023 оны жилийн жилийн байдлаар/

2023 оны 12 сарын 28 өдөр Улаанбаатар хот

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Монгол Улсын хууль** | | | | | | |
| 1 | 1 | Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1997-06-05 Дугаар 1997.06.05 | 11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна. | Захиргаа, удирдлагын газар салбарын статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд "Эм зүйн салбарын үзүүлэлт 2022 он" судалгааны эмхэтгэлийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 500 ширхэгийг хэвлэн гаргасан. | 100% | |
| 2 | 2 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны 05 дугар сарын 10-ны өдрийн Журам батлах тухай А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу газрын дарга байгууллагын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр төлөвлөгөөг баталсан. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Газрын 25 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулах, зэрэг дэвийг ахиулах саналыг албан бичгээр холбогдох тушаал шийдвэрүүд, өмнөх оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний хуудас зэргийг 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр 01/365 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яаманд | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлсэн. ЭМЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай" 10 дугаар тогтоолоор шинээр 5 албан хаагчид зэрэг дэв олгож, 20 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан.<br>Мөн Эрүүл мэндийн яам болон Худалдаа хөгжлийн банкны байгуулсан санамж бичгийн хүрээнд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад банкны бүтээгдэхүүн үйлчилгээ танилцуулах өдөрлөгийг зохион байгуулсан. Уг гэрээний дагуу албан хаагчдад орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломж бүрдэж, 3 албан хаагч ипотекийн зээлэнд хамрагдсан.<br>Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолын дагуу түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулахаар нийт албан хаагчдаас орон сууцны судалгаа авч, Нийслэлийн орон сууцны корпорацид 01/1721 дугаар албан бичгээр хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн.<br>Байгууллагын нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, 6 чиглэл бүхий 34 сургалтыг гаднаас болон дотоодын нөөц боломжоороо зохион байгуулсан. | | |
| 3 | 3 | Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/ | 20.3. Донорын цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд, эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн хяналт нь дор Улсын хилээр нэвтрүүлэх бараанд импорт, экспортын лиценз олгох журам"-ын хүрээнд 2023 онд 11 байгууллагад /АШУҮИС, Био системс ХХК, Зүүн Азийн Залуучуудын Наадмын Зохион Байгуулах Хороо ХК, Си Эл Дабльюю ХХК, МУИС Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Ливер центр, Мон-Адонис, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага, Реженератив, ХӨСҮ, иргэн / 125 удаагийн экспортын лицензээр 15456 ширхэг цус, цусан бүтээгдэхүүн, шээс, сорьцод лиценз олгосон. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | 4 | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | 7.1.14. цар тахлаас хамааралгүйгээр хийгдэж байгаа бүтээгдэхүүний экспортыг хориглохгүй бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл, хүнсний болон бусад шаардлагатай барааг улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ | Мон-Интра, Ариун Монгол, Одь-тан, Эм Эс Ай Си Си ХХК зэрэг 2023 онд нийт 4 байгууллагын 37 экспортын лицензээр 169 нэрийн уламжлалт эм экспортлосон байна. | 100% | |
| | 5 | | 7.1.15. цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ | МУ-ын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/163, А/603 тушаалын дагуу цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг тогтмол хийж, хэрэгцээг халдварын тархалтын тооцоололтой уялдуулан тооцоолж, нөөц бүрдүүлэх чиглэлээр ханган нийлүүлэх байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг улсын хэмжээний нөөцийн нэгдсэн программ burtgel.mohs.mn-аар өдөр бүр, зах зээлийн нөөц болон импортын мэдээллийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч, мэдээний санд бүртгэж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг удирдамжид нийцүүлэн гаргаж, 6 нэрийн вирусийн эсрэг эм, 9 нэрийн антибиотик, 5 нэрийн амилуулах тусламж, үйлчилгээний эм, 11 нэрийн дуслын шингэн, шинж тэмдгийн эсрэг эм, 14 нэрийн хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээ ба шаардлагатай төсвийг тухай бүр ХӨСҮТ-өөс ирүүлсэн КОВИД-19 халдварын тохиолдлын таамаглалд үндэслэн тооцоолсон. | | Хяналтаас хасуулах саналтай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 6 | | 7.1.23. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах;<br>/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ | 1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбар, ЭМБ-д шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/46 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсэг ЭМБ, мэргэжлийн салбар зөвлөлүүдээс санал авч боловсруулан хэрэгцээг ЭМБ-ын 2021, 2022 оны худалдан авалтын тайланд үндэслэн тооцоолсон. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/211 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбар, ЭМБ-д /шатлал тус бүрээр/ шаардлагатай 46 нэрийн эм, 37 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 11 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 7 нэр төрлийн ариутгал, халваргүйтгэлийн бодис, 18 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт батлагдсан.<br>2. Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын хангамжийн зохицуулалт хийсэн.<br>3. ҮАБЗ, Шадар сайдын ажлын алба, ОБЕГ, НЗДТГ-ын хамтарсан “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” стратегийн команд штабын сургуулилтад 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг хангаж оролцсон. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4. 2023 онд ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг 25 нэрээр /олон улсын нэршлээр/ нэмэгдүүлж, төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс төрийн өмчийн 133 байгууллага 149 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн нийт 43,2 тэрбум төгрөгийн захиалга хийж, улсын төсвөөс 4,0 тэрбум төгрөгийн хэмнэлт хийсэн байна. Ерөнхий гэрээгээр 2024 онд худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг 37-оор нэмэгдүүлэхээр саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. | | |
| | 7 | | 9.4. Халдварт өвчнөөс хамгаалах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эмнэлгийн хэрэгсэл хангах нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага улсын хилээр оруулах бөгөөд хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | 2023 оны Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 132 дугаар тогтоол "КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ОНОШЛУУР, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БОДИСЫН ЖАГСААЛТ"-ын хүрээнд 3 байгууллага 15,200,000 ширхэг нэг удаагийн малгай, 1 байгууллага 1280 ширхэг нүүрний хаалт, 1 байгууллага 150,000 ширхэг N95 маск, 10 байгууллагын 28,538,680 ширхэг нэг удаагийн амны хаалт, 3 байгууллага 6080 ширхэг нэг удаагийн халад, 6 байгууллага 31,500,000 ширхэг нэг удаагийн улавч, 10 байгууллага 178,251,700 ширхэг үзлэгийн бээлий, 8 байгууллага 2,228,000 ширхэг мэс заслын бээлий зэрэг эмнэлгийн хэрэглүүдийг тус тус импортлосон байна. | -- | Хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 8 | | 9.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цар тахлын халдварын эмчилгээнд шаардлагатай шинэ төрлийн эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг түргэвчилсэн журмаар бүртгэнэ. | 1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нэн шаардлагатай эмэнд яаралтай горимоор зөвшөөрөл олгох журмын төслийг боловсруулж, 01/824 дугаар албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>2. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/33 дугаар тушаалын хүрээнд 2023 онд Коронавируст халдвар (COVID-19)-ын эмчилгээ, оношилгооны түр зааварт орсон 8 нэрийн эм, 7 нэрийн оношлуурыг бүртгэсэн.<br>3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Pfizer-BioNTech COVID-19 Bivalent (Original and Omicron BA.4/BA.5) вакциныг нөөц бүрдүүлэх зорилгоор яаралтай горимоор зах зээлд гаргах зөвшөөрөл олгосон. | 100% | |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | |
| 5 | 9 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.14. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах. | 1. ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан "Эмийн үйлдвэр, эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй нийт 366 эмийн сан, 4 эм ханган нийлүүлэх байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 10.16.1 кодтой "Эмийн сангийн үйл ажиллагааг шалгах", 10.16.2 кодтой "Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний хадгалалт, түгээлтийг шалгах" хяналтын хуудсуудаар үнэлэхэд 218 байгууллага бага, 127 байгууллага дунд, 21 байгууллага их эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн ба шалгалтаар илэрсэн дутагдлуудыг арилгуулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 2204 заалт бүхий 235 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Хяналт шалгалтын явцад 9 байгууллагад илэрсэн хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хадгалалтын горим алдагдсан нийт 119 нэрийн 3130 ширхэг 2360710 төгрөгийн үнэ бүхий эм, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээгдэхүүнийг Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн устгуулж, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан. ЗТХ-ийн хүрээнд 48 нэрийн 1805 ширхэг 2024100 төгрөгийн зөрчилтэй бүтээгдэхүүнийг шийдвэрлүүлэхээр орон тооны бус устгалын комисст шилжүүлсэн. Мөн 2 иргэн, 18 ААН-д 10.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулсан.<br>2. ЭМЯ-ны Салбарын хяналтын газар, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга нарын хамтран баталсан "Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд ЗГ-ын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр хамтарсан 193, дангаар 12 аймгийн 73 эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс хамтарсан 186 байгууллага, дангаар 64 эрүүл мэндийн байгууллага буюу нийт төлөвлөсөн объектын 95,7 хувийг хамруулсан. Шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудыг 10.17.1 кодтой "Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах" хяналтын хуудсаар үнэлэхэд хамрагдсан 250 байгууллагын 109 буюу 43,6% бага, 112 буюу 44,8% дунд, 29 буюу 11,6% их эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>3. Улсын байцаагчийн хяналт шалгалтаар арга хэмжээ авах эрх үүсээгүй, прокурорын харьяалал тогтоогдоогүй хүртэлх хугацаанд хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын үед илэрсэн хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй 391 нэрийн 10790 ширхэг, 21438850 төгрөгийн үнэ бүхий эм, бүтээгдэхүүнийг МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дотоод хяналтын багаар устгуулах арга хэмжээ авч, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор хамтарсан шалгалтаар 1696 заалт бүхий 141 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, дангаар 841 заалт бүхий 45 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж, зөрчил гаргасан 5 байгууллага, 4 албан тушаалтанд 9.0 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулан барагдуулж, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй 72 нэрийн 6823 ширхэг 8120262 төгрөгийн эм бэлдмэлийг хураах, зохих журмын дагуу шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.<br>Хяналт шалгалтын нэгдсэн дүнг 01/1859 дугаар албан бичгээр ЭМЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | | |
| **УАБЗ-ийн зөвлөмж** | | | | | | |
| 6 | 10 | Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03 | 1. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх бие даасан эмийн эсвэл эм, хүнсний зохицуулалтын асуудал эрхэлсэн нэгдсэн агентлагийг бусад улс орны жишгийн дагуу байгуулах; | Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг зохицуулалтын чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг Засгийн газрын 2020 оны 222 тогтоолоор байгуулж, 2021 оны 378 дугаар тогтоолоор эм биобэлдмэлийн хяналтын чиг үүргийг тус агентлагт нэгтгэсэн. | | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 11 | | 2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох; | 1. Гаалийн мэдүүлгийн системээс Эмийн бүртгэлийн Лайсмед програмд дараах баганууд нэмэгдэж, эм тус бүрийн гаалиар орж ирсэн мэдээллийг бодитоор харах боломж бүрдсэн. Үүнд: | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Импортлогдсон тоо хэмжээ<br>- Үндсэн үнэ<br>- Нэмүү өртөгтэй үнэ<br>- Импортлогдсон огноо<br>- Бараа нийлүүлэх нөхцөлийн код<br>- Валютын код<br>- Валютын ханш<br>2. Гаалийн ерөнхий газартай гэрээ байгуулахаар 2023 оны 01/119 дүгээр албан бичгээр гэрээний төслийг хүргүүлсэн. Гаалийн ерөнхий газраас 2 талын гэрээ нь хууль, зүйн үндэслэлтэй байгаа боловч "Үндсэн үнэ", "Нэмүү өртөгтэй үнэ" гаалийн байгууллагаас гарах боломжгүй харин "Гаалийн үнэ" гарах боломжтой тухай албан бичиг ирүүлсэн. Үүний дагуу гэрээний төслийг шинэчлэн 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/349 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | 12 | | 6. Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох | 1. Хэрэгжиж буй эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглосон эрх зүйн зохицуулалт байхгүй учраас Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох саналыг өгсөн.<br>2. ДЭМБ-ын санхүүжилтээр 2023 оны 01 дүгээр сараас 2023 оны 02 дугаар сард түгээсэн зар сурталчилгаанд тандалт үнэлгээ хийсэн. Үүнд: Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх 22 байгууллагын 46 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тандалт үнэлгээ хийсэн.<br>3. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн 46 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны 30 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа 65.2% нь зөвшөөрөл авсан. 16 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний 34.7% зөвшөөрөл аваагүй түгээсэн байна.<br>4. Монголын улсын харилцаа холбооны зохицуулах хороонд 01/825 дугаар албан бичгээр "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-д Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын санал хүргүүлсэн.<br>5. Цахим орчин (facebook) дах хувь хүн, цахим дэлгүүрийн эм, БИБ-ний сүүлийн 1 сарын хугацаан дах зар сурталчилгааны агуулга бүхий нийтлэлүүдэд тандалт хийхэд цахим дэлгүүрийн зар сурталчилгаа-4, эм ханган нийлүүлэх байгууллагын цахим хуудасын сурталчилгаа-8, гоо сайханы эмнэлэг-11, уламжлалтийн эмнэлэг-1, эмийн сан-3, хувь хүний зар сурталчилгаа-67 нийт 92 зөвшөөрөлгүй зар сурталчилгаа илэрч давтагдсан тоогоор 74 нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнүүд дурьдагдсан байна. Тандалтаар нийт зар сурталчилгааны 82.8% нь бүртгэлгүй эм, БИБ ээлж, түгээж байгаа зар сурталчилгааны 72.8 хувь иргэдийн нийтэлсэн эмийг албан бус нэршилээр, эмийн зургийг байршуулан сурталчилгааг хийсэн байна. ДЗХ-аар тайлан танилцуулж, тайланг гаалийн ерөнхий газар хүргүүлсэн. | | |
| 7 | 13 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай<br>2018-02-05<br>Дугаар 2018_06/05 | 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргасан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | "Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаалт"-ы шинэчлэхээр төсөлд ЦЕГ, СЭМҮТ, УГТЭ, УНТЭ, НЭМГ, ЭМДЕГ болон газар, хэлтсийн дарга нараас саналыг авч тусгасан.<br>Жагсаалтын төсөлд Габапентин эмийг оруулах эсэх талаар ЭМЯ-ны Мэдрэл судлалын мэргэжлийн салбар зөвлөлд 01/468 дугаар албан бичгийг хүргүүлж, санал дүгнэлтийг авсан.<br>"МУ-ын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаалт" Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/196 дугаар тушаалын 2- | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | р хавсралтаар батлагдсан. Жагсаалтад мансууруулах 14, сэтгэцэд нөлөөт 36 эм багтсан. Сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтаас клотиазепам, меатамфетаминыг хасч, флунитразепамыг нэмэхээр тусгасан. Журам, жагсаалтыг бүртгүүлэхээр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам руу хүргүүлсэн. | | |
| **ЗГ-ын тогтоол** | | | | | | |
| 8 | 14 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 | 1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | 2023 оны байдлаар давхардал, хийдэл байхгүй болно. | 100% | |
| | 15 | | 1.4. Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | Албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, хууль тогтоомж, журмын хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхүүлэхээр Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлд 4 удаагийн шалгалтын захиалгыг өгч шалгалт зохион байгуулагдсан. Үүнд:<br>- Шалгалтын захиалгын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр төрийн захиргааны албан хаагчийн удирдах албан тушаалын 7, гүйцэтгэх албан тушаалын 30 нийт 37 сул орон тоог зарласан. Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 06 дугаар тогтоолын дагуу шалгалтад тэнцсэн 27 иргэнийг албан тушаалд томилсон.<br>- 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдөр төрийн захиргааны албан хаагчийн удирдах албан тушаалын 2, гүйцэтгэх албан тушаалын 12 нийт 14 сул орон тоог зарласан. Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 07- | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ны өдрийн "Нэр дэвшүүлж, санал болгох тухай" 12 дугаар тогтоолын дагуу шалгалтад тэнцсэн 7 иргэнийг албан тушаалд томилсон.<br>- 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр төрийн захиргааны албан хаагчийн удирдах албан тушаалын 2, гүйцэтгэх албан тушаалын 7 нийт 9 сул орон тоог зарласан. Тус шалгалтад тэнцсэн иргэн байгаагүй.<br>- 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр төрийн захиргааны албан хаагчийн удирдах албан тушаалын 2, гүйцэтгэх албан тушаалын 10 нийт 12 сул орон тоог зарласан. Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн "Нэр дэвшүүлж, санал болгох тухай" 21 дүгээр тогтоолын дагуу шалгалтад тэнцсэн 2 иргэнийг албан тушаалд томилсон.<br>Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх сэлгэн ажиллуулах тухай зарыг байгууллагын цахим хуудсанд 4 удаа байршуулж, 3 сул орон тоог нөхсөн. | | |
| | 16 | | 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | Жирэмсний болон амаржсны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа төрийн жинхэнэ 11 албан хаагчийн сул орон тоонд гэрээт ажилтан томилоогүй бөгөөд хамгийн ойр мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 17 | | 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | Албан хаагчдаас албан томилолтын явцад болон ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансуурах сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, хүйтэн болон халуун зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис нэвтрүүлэх, хадгалах, ашиглах, хэрэглэхгүй байх асуудлыг газрын даргын 2022 оны 189 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "ЭЭХХЗГ-ын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.6.2 дахь заалтаар зохицуулсан. Жилийн байдлаар албан хаагчид энэ төрлийн зөрчил гаргаагүй болно. | 100% | |
| | 18 | | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, санал жилийн эцсийн байдлаар ирээгүй. Агентлагийн дэргэдэх ёс зүйн зөвлөл 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай хэрэгжсэн. | 80% | |
| | 19 | | 1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор, цаг бүртгэлийн төхөөрөмжөөс нийт албан хаагчдын хурууны хээний мэдээллийг устгаж, албан даалгаварт заасны дагуу цаг бүртгэлийн төхөөрөмж дээр албан хаагчдыг царайгаар таниулж, ажлын цагаа бүртгүүлэх тохиргоог хийсэн. Мөн албан хаагчдын цагийн ашиглалт, бүртгэлд сар бүр 2 удаа программ болон гадуур ажлын дэвтэрт тулган хяналтыг хийж ажилласан. | 100% | |
| | 20 | | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, зэрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/189 дүгээр тушаалын хавсралтаар "ЭЭХХЗГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 6.3.1.1.-т "Аливаа хууль бус шахалт болон ажлын байрны дарамтад өртсөн гэж үзвэл өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах" заалтыг тусгаж ажилласан. Тайлант хугацаанд удирдах болон | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гүйцэтгэх албан тушаалтнаас ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт үзүүлсэн талаарх гомдол, мэдээлэл "Ёс зүйн зөвлөл" болон байгууллагын захиргаанд ирүүлээгүй байна. | | |
| | 21 | | 3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Байгууллагын үйл ажилгаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ 8 удаа хийсэн. Үүнд:<br><br>Захиргаа, удирдлагын газрын албан хэрэг хөтлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр батлуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан зөвлөмжийг холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулсан.<br><br>1. Албан хэрэг хөтлөлтийн зохион байгуулалт, албан бичгийн бүртгэл, шийдвэрлэлтийн байдалд хяналт хийх удирдамжийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр батлуулж, хяналтыг хийж холбогдох мэргэжилтэн зөвлөмж өгсөн.<br>2. Эмийн бүртгэлийн хэлтсийн 2021, 2022, 2023 оны 5 дугаар сарын 01-ний хүртэлх эмийн бүртгэлийн материалд дүн шинжилгээ хийх удирдамжийг 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлуулж, дотоод хяналтыг удирдамжийн дагуу хяналт хийж, зөвлөмжийг ЭБХ-т хүргүүлсэн.<br>3. Санхүүгийн 2023 оны 04-05 сарын санхүүгийн баримтад төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хийсэн.<br>4. Агентлагийн даргын 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/197 дугаар тушаалаар лабораторийн нөхцөл байдалд үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, 4 чиглэлийн хүрээнд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж, лабароторит хүргүүлсэн.<br>5. Хууль тогтоомжийн хяналтад Монгол улсын 4 хуулийн 8 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт, УАБЗ-ийн 2 зөвлөмжийн 4 заалт, ЗГ-ын 5 тогтоолын 12 заалт, Засгийн газрын 5 | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуралдааны тэмдэглэлийн 7 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 5 заалт буюу нийт 37 заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 01/895 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>6. Яам, Засгийн газрын агентлагаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актуудын хуульд нийцсэн байдал, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах асуудлыг судлан хяналт шинжилгээ үнэлгээ хийж, ЭМЯ-нд хүргүүлсэн ба даргын зөвлөлийн хурлаар илэрсэн асуудлын талаар танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж мэдээлэл өгсөн.<br>7. ААНБ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, удирдлагад танилцуулсан.<br>8. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох мэдээллийг боловсруулж, ЭМЯ-ны салбарын хяналтын газрын даргад хүргүүлсэн. | | |
| 9 | 22 | Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139 | 3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай. | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны 5 багц сургалт нийт 11 албан хаагчийг сургалтад хамруулсан. Үүнд:<br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-1<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-3<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-2<br>- Ахлах түшмэлийн багц сургалт-3<br>- Эрхэлсэн түшмэлийн багц сургалт-2<br>Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх-1 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | 23 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-05-25<br>Дугаар 2022_203 | 1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2.жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх. | Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу, байгууллага үндсэн үйл ажиллагааны чиглэлээр цахимаар 20 хурал, зөвлөгөөн зохион байгуулсан. Төсвийн тухай хуулийн 12.1.4. жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглабарыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, 8.4.1. төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх гэж заасны дагуу хуулийн хугацаандаа хүргүүлэхээр газар хэлтсийн 2024 оны төсвийн төслийн саналыг авч нэгтгэж хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллав.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2023 онд боловсруулаагүй мөн энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | 24 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204 | 9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Автомашины хэрэглээг хязгаарласан төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 13-ны А-1/1236 дугаар албан бичгийн дагуу Засгийн газрын авто баазад 73-21 УБЗ спортеж автомашиныг 2022 оны 06 дугаар сарын 20-өдөр хүлээлгэн өгсөн. Фургон автомашиныг ЭМЯ-нд хүргүүлж балансаас балансад шилжүүлэх хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохиуулалтын газар албан бигээр хүргүүлсэн. Байгууллагын өмчөөс хасагдсан. | | Хяналтаас хасуулах саналтай байна |
| 12 | 25 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Хуулийн хэрэгжилтийг ханган төрийн албан хэрэг хөтлөлтийг 2025 оноос эхлэн Монгол хэл, үндэсний бичгээр зэрэгцүүлэн хөтлөх болсонтой холбогдуулан байгууллагын 63 албан хаагч 2023 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл Моном Төгөлдөр сургалтын төвийн үндэсний бичгийн хичээлд танхимаар болон цахим хэлбэрээр хамрагдсан. Сургалтад хамрагдсан 63 албан хаагч сургалтын төвийн түвшин тогтоох шалгалтыг өгч гэрчилгээ авсан. | 100% | |
| **3Г-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | 26 | 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69 | Ү.Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав. | Төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжтэй холбоотой 792 удаагийн дуудлага, дотоод сүлжээний засвар, үйлчилгээ, тохируулга холболтын 263 удаагийн дуудлагаар асуудлыг шийдвэрлэж, шинээр 20 албан хаагчдын компьютерт SSD HARD DISK DRIVE суурилуулсан.<br>2. Газар, хэлтсүүдийн үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд:<br>И-Монголиа нэгдсэн платформд 6 үйл ажиллагаа цахимжуулах тухай албан хүсэлтийг И-Монголиа УТҮГ-т хамтран ажиллах тухай 01/433 дугаар албан бичгийг илгээсэн. Үүнд:<br>- Эм үйлдвэрлэлийн хэлтэс-3<br>- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар-3<br>3. Байгууллагын онц чухал мэдээллийн сантай ажилладаг албан хаагчидтай нууцын гэрээ байгуулсан. Үүнд:<br>- Эмийн бүртгэл мэдээний сан хариуцсан мэргэжилтэн-2023/01 дугаар гэрээ<br>- Байгууллагын дотоод сүлжээний асуудал хариуцсан инженер -2023/02 дугаар гэрээ<br>4. “Лайсмэд” программ хангамжийн өгөдлийн сангаас Монгол улсад бүртгэлтэй эмийн мэдээллийг хувийн болон төрийн хэвшлийн байгууллагаас авах хүсэлт ирсний дагуу тус мэдээллийг төрийн мэдээллийн нэгдсэн "Хур" системд сервис холболт хийх тухай 01/698 дугаар албан бичгийг Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монголиа академид хүргүүлсэн.<br>5. “Эрүүл мэндийн салбарын цахим системүүдийн хооронд өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх” | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрүүл мэндийн сайдын А/391 дугаар тушаалын дагуу байгууллагын тоон гарын үсгийг нэвтрүүлж, “ХУР” системийн техникийн шаардлагыг бүрдүүлсэн. | | |
| 14 | 27 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.1. Коронавируст халдварын дараахь нөхөн сэргээх эмчилгээг эрчимжүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг энэ оны 5 дугаар сарын 1-ээс эхлэн орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин нарт тус тус даалгав; | Эрүүл мэндийн сайдын 2022 оны Журам батлах тухай А/139 дүгээр тушаалын хүрээнд эрт илрүүлэгт оролцож буй эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дагуу нийт 50 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмнэлэгт төлөвлөгөөт бус зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, илэрсэн зөрчлийн хүрээнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 265 заалт бүхий 15 улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ЭЭХХЗГ-ын даргын А/78 дугаар тушаалаар эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардлагатай лабораторийн урвалж, оношлуур, хэрэгслийн хангамжийг зохицуулах, чанар, аюулгүй байдалд хяналт тавих, зах зээлийн үнийн судалгаа хийх ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө гарган ажилласан. ЭЭХХЗГ-ын чиг үүрэг болох “Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотойгоор” эрт илрүүлэгт шаардлагатай жагсаалтыг гарган тасалдал үүсгэхгүйгээр 7 хоног болгон Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардлагатай 52 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурын нөөцийн улсын хэмжээний мэдээллийг 7 хоногт 2 удаа эрүүл мэндийн байгууллагууд, ханган нийлүүлэх байгууллагуудаас burtgel.mohs.mn программаар авч нэгтгэн, хэрэгцээт оношлуур, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг ханган нийлүүлэх байгууллагуудад мэдэгдэж татан авах ажлыг зохион байгуулж ажилласан. Нөөц бүрдүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, мэдээлэл солилцох зорилгоор ЭМБ-уудтай 6 удаа, ханган | | Хяналтаас хасуулах саналтай байна |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийлүүлэх байгууллагуудтай 7 удаа танхимаар болон цахимаар тус тус уулзалтуудыг зохион байгуулсан. | | |
| | 28 | | X.5. 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | 2023 оны жилийн эцсийн байдлаар Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд дуудлагаар 142, цахим шуудангаар 3, дуут шуудангаар 4, веб хуудсаар 11, биечлэн 3 буюу нийт 163 гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс 96,9 хувь буюу 158 нь шийдвэрлэгдсэн, 3.1 хувь буюу 5 өргөдөл, гомдол судалж буй төлөвт байна.<br>Нийт ирсэн өргөдөл, гомдлын 46,1 хувийг эмийн тасалдал, эмийн хангамж, хүртээмж болон үнийн өсөлт, 15,9 хувийг эмийн чанар, аюулгүй байдал, 38%-ийг бусад асуудал эзэлж байна.<br>Өргөдөл гомдлыг хүлээн авсан даруйд иргэнтэй холбогдон тодруулга авч, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтыг зохион байгуулах, өөр бусад байгууллагаас мэдээлэл авах арга хэмжээг авч иргэнд эргэн мэдээлж өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж байна. | 100% | |
| 15 | 29 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16<br>Дугаар 2022_16 | XYIII.2.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хүрээнд “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг дэмжиж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав. | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхээр нийт албан хаагчдын дунд биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын 4 төрөлт тэмцээнийг 2023 оны 5 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Нийт 70 гаруй албан хаагчид оролцсон.<br>Мөн“Энэ жилдээ-эрүүл жиндээ” аяны хүрээнд албан хаагчдын цэвэр агаарт алхах үйл ажиллагааг 2023 оны 6 дугаар сарын 17-ны өдөр нийт албан хаагчдад зохион байгуулсан. | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 30 | | XYIII.17.2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав; | ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/41 дүгээр "Ажлын байрны түрээс" нэртэй тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хороо байгуулах тухай тушаал батлагдсан. Тус тушаалын дагуу үнэлгээний хороог нийт 11 удаа хуралдуулж, тус тендерийг 3 удаа 30 хоног зарлахад нэг ч оролцогч оролцоогүй, 2 удаа хялбаршуулсан байдлаар зарлахад Булнайн-Ар ХХК буюу нэг оролцогч оролцсон боловч тендерийн баримт бичиг болон үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагын шалгуурыг хангаагүй тул тендерийн сонгон шалгаруулалтад тэнцээгүй болохыг албан бичгээр тус компанид мэдэгдэж, зөвлөмжийг агентлагт тус тус хүргүүлсэн. | | |
| 16 | 31 | 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27 | XYIII.2.13. Төрийн хүнд суртлыг арилгах авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч тухай бүр нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Байгууллагын 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх талаар тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Байгууллагын албан ёсны www.mmra.gov.mn цахим хуудасны ил тод хэсэгт "Авлигын талаарх мэдээлэл, гомдол, санал хүлээн авах" цэстэй болсон. Мөн "Авлигатай тэмцэх таван Ш ажиллагаа"-ны хүрээнд шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх шторк, постерийг байгууллагын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээсэн. | 100% | |
| 17 | 32 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_ | XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим | "Tridum" ХХК-тай гэрээ байгуулан эхний удаад байгууллагын газар хэлтсийн дарга нар болон бичиг хэргийн ажилтанд нийт 10 хэрэглэгчид тоон гарын үсгийн төхөөрөмжийг худалдан авч хүний нөөц, бичиг хэргийн "Able" програм хангамжид холбож дотоод албан бичиг солилцох, боловсруулах үйл ажиллагааг тоон гарын үсэг ашиглан цахимаар солилцдог болсон. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | | | |
| **ЗГ-ын албан даалгавар** | | | | | | |
| 18 | 33 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай<br>2019-10-16<br>Дугаар 2019_03 | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | “Tridum” ХХК-тай гэрээ байгуулан эхний удаад байгууллагын газар хэлтсийн дарга нар болон бичиг хэргийн ажилтанд нийт 10 хэрэглэгчид тоон гарын үсгийн төхөөрөмжийг худалдан авч хүний нөөц, бичиг хэргийн “Able” программ хангамжид холбож, дотоод албан бичиг солилцох, боловсруулах үйл ажиллагааг тоон гарын үсэг ашиглан цахимаар солилцдог болсон. | 100% | |
| 19 | 34 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай<br>2020-11-19<br>Дугаар 2020_2 | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх ажлын хүрээнд И Монголиа цахим үйлчилгээний нэгдсэн порталд эмийн бүртгэлийн 6, импортын лицензийн 5 үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Мөн И Монголиа Академи УТҮГ руу 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/433 дугаар албан бичгээр И Монголиа цахим үйлчилгээний нэгдсэн санд эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын 3 үйлчилгээ, эм үйлдвэрлэлийн хэлтсийн 1 үйлчилгээг шинээр оруулах тухай хамтран ажиллах санал болон 4 үйлчилгээний мэдээллийг явуулсан.<br>E-Business платформд "Шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг"-ийн шинэ цэс нэмэх тухай 01/1101 дугаар албан бичиг хүргүүлж, 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн тухайн цэс нэмэгдсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 35 | | 1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан "Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журмыг шинэчлэн боловсруулж. журмын төсөлд бүртгэлийн материалыг Төрийн үйлчилгээний цахим системээр авахаар талаар эрх зүйн зохицуулалтыг оруулсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/48 дугаар тушаалаар "Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын бүртгэл олгох" стандарт ажиллагааны заавар батлуулсан. | 80% | |
| | 36 | | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Цахимаар үзүүлж буй үйлчилгээний талаар 2023 оны жилийн эцсийн байдлаар олон нийтэд байгууллагын албан ёсны цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дараах байдлаар сурталчилсан.<br>Үүнд:<br>1. Улсын хилээр нэвтэрч буй эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, эмийн дээж, оношлуур, урвалжид олгосон бүртгэлийн мэдээллийг 7 хоног тутам /Нийт 12/<br>2. Тусгай зөвшөөрлийн комисс нь 21 хоногт 1 удаа хуралддаг бөгөөд хурлын шийдвэрийг тухай бүр нь /Нийт 4/<br>3. Монгол улсын хэмжээнд эмчилгээ, оношилгоонд хэрэглэх эм, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг нотолгоонд суурилсан чанар, аюулгүй байдлын холбогдох бичиг баримт, шинжилгээний дүнд үндэслэн бүртгэх, бүртгэлийг сунгах, хаягийн өөрчлөлт хийх зэрэг үйл ажиллагаатай холбоотой Хүний эмийн зөвлөлийн хурлын шийдвэрийг тухай бүр /Нийт 4/, Биологийн идэвх бүтээгдэхүүний салбар зөвлөлийн хурлын 1 шийдвэр<br>4. 2023 оны жилийн эцсийн байдлаар эмийн 1267, оношлуурын 386, БИБ-ий 442, эмийн түүхий эдийн 49, нийт 2144 мэдээллийг шинэчлэн оруулсан.<br>5. Иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 7 хоног тутам /Нийт 15/<br>6. ДЭМБ-аас гаргасан эмийн орц найрлага, гаж нөлөөтэй холбоотой зах зээлээс эргүүлэн татаж буй сэрэмжлүүлэг мэдээллийг тухай бүр /Нийт 7/<br>8. Иргэд, эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан "Эмийн зохистой хэрэглээ"-ний талаар уриалга, сэрэмжлүүлгийн агуулгатай 10 постерийг тус тус нийтэлсэн.<br>9. ЭМС-ын 2022 оны А/415 дугаар тушаалаар батлагдсан 34 бүртгэлийн шинжээчдийн хувийн мэдээллийг E-Business цахим цахим системд шинээр бүртгэн, бүртгэлийн шинжээчдэд нэвтрэх нэр, нууц үгийг илгээж, E-Business платформыг хэрхэн ашиглах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | | |
| | 37 | | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, лавлах бүртгэлийн үйл ажиллагаар www.intranet.gov.mn домайн нэр бүхий онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг гэрээний дагуу хэрэглэж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 7811 албан бичиг, 511 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүссэн нийт 2266 албан бичгийг холбогдох иргэн болон байгууллагад хүргүүлсэн. | 100% | |
| **Үнэлгээний дундаж дүн** | | | | | **97,4 %** | |